

“БӨХӨГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 11-ний өдрийн

№01

Улаанбаатар хот

“Бөхөг” ХК-ийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд дүгнэлт өгөх тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.11 дэх заалтыг үндэслэн “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Бөхөг” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл нь тус компанийг удирдах үйл ажиллагаандаа Компанийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шийдвэр, “Бөхөг” Хувьцаат компанийн дүрмийг мөрдөж, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гаргасан шийдвэрийн хэрэгжилтэнд хяналт тавин ажилласан. Төлөөлөн удирдах зөвлөл нь баталсан “Бөхөг” ХК-ийн 2023 оны бизнес төлөвлөгөө нь компанийн хөрөнгө оруулагчийг олж үйл ажиллагааг эхлүүлэх байлаа. Гүйцэтгэх удирдлага идэвхи санаачлагатай ажиллан гадаадын хэд хэдэн хөрөнгө оруулагчид танилцуулан судлуулах ажиллагаа хийгдэж ажилласаныг дурьдсугай.

2. “Бөхөг” хувьцаат компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаар компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг хэлэлцэн, бизнес төлөвлөгөөний биелэлт хангалттай гэж үзэн, “Бөхөг” ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлт, 2024 оны зорилтыг Монгол Улсын Компанийн тухай хууль болон “Бөхөг” ХК-ийн дүрмийн хүрээнд Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Дүгнэлт гаргасныг тус компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *Б.ДАВААСҮРЭН* Б.ДАВААСҮРЭН

“БӨХӨГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 11-ний өдрийн

№02

Улаанбаатар хот

Ногдол ашгийн тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5, 46.6 дахь хэсгийг үндэслэн “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас ТОГТООХ НЬ:

1. “Бөхөг” Хувьцаат компанийг дахин хөрөнгөжүүлэх асуудал шийдвэрлэх боломжгүй байдлаас болж үйл ажиллагааны үндсэн чиглэл болсон:

- шувууны аж ахуй эрхлэх,

- шувууны мах, өндөг бэлтгэх, борлуулах үйл ажиллагаа бүрэн зогссон, үүнтэй холбоотойгоор орлого орохгүй болж ямар ч санхүүжилтгүй болсон, мөн бусдад төлөх их хэмжээний татварын, зээлийн болон бусад өр төлбөртэй байгаагаас шалтгаалан хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах боломжгүй болохыг нийт хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

2. Дээрх шийдвэртэй холбогдуулан санхүүгийн тайлан болон бусад шаардлагатай баримт, материалуудыг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд тайлагнахыг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДАВААСҮРЭН

“БӨХӨГ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03-р сарын 11-ний өдрийн

№03

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол улсын Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1 дэх хэсгийг үндэслэн “Бөхөг” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас **ТОГТООХ НЬ**:

1. “Бөхөг” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 10⁰⁰ цагт Хан-Уул дүүргийн 13-р хороонд орших “Бөхөг” ХК-ийн байрны хурлын танхимд хуралдуулсугай.

2. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараахь асуудлуудыг хэлэлцүүлсүгэй.

А. Компанийн 2023 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаархи ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах,

Б. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон бизнес төлөвлөгөөг батлах,

В. Их хэмжээний хэлцэл хийх, хувьцаа нэмж гаргах асуудлыг шийдвэрлэж ТУЗ-д эрх олгох эсэх,

Г. ТУЗ-ийн ногдол ашиг тараах эсэх талаар гаргасан тогтоолыг хэлэлцэж батлах,

3. Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөр, саналын хуудсаар өгөх сүүлчийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 23-ны өдрөөр тус тус тасалбар болгон тогтоосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн шийдвэрийг шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, “Монголын хөрөнгийн бирж” ТӨХК-д хүргүүлэх, хурлын зарыг өдөр тутмын 2-оос доошгүй сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг телевиз болон Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудсаар дамжуулан холбогдох журмын дагуу зарлуулж, хувьцаа эзэмшигчдэд хүргэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг/-д даалгасугай.

5. Хувьцаа эзэмшигчдийн хуралтай холбоотой хувьцаа эзэмшигчдэд танилцуулах баримт бичгийн жагсаалтыг хавсралт №01, санал авах хуудсыг хавсралт №02, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга, тооллогын комиссын дарга, гишүүдийн бүрэлдэхүүнийг хавсралт №03-т зааснаар баталсугай.

6. Хувьцаа эзэмшигчдэд компанийн 2023 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайлан болон хурлаар хэлэлцэх бусад баримт бичгийн жагсаалттай танилцах боломжоор хангах, хурлын зарыг өдөр тутмын мэдээллийн хэрэгслээр дамжуулан мэдэгдэхийг Гүйцэтгэх захирал /Ц.Ганцэцэг /-д үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДАВААСҮРЭН